

НИЙТЭД САНАЛ БОЛГОН ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. НИЙТЭД САНАЛ БОЛГОН АНХ УДАА ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ

- 2.1. Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргах
- 2.2. Үнэт цаас гаргагчийн хүсэлтийг хянах
- 2.3. Хорооны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах, үнэт цаасны танилцуулгыг олон нийтэд танилцуулах
- 2.4. Анхдагч зах зээлд арилжаалах, тайлагнах, бүртгэлийг хүчингүй болгох

ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ, АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА, ХОРООНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Үнэт цаас гаргагч нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ
- 3.2. Арилжаа эрхлэх байгууллага дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ
- 3.3. Хороо нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ

ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 4.1. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах
- 4.2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах, хүсэлтийг хянах, Хорооны бүртгэлд өөрчлөлт оруулах

ТАВ. ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

- 5.1. Үнэт цаасыг Хорооны бүртгэлээс хасуулах хүсэлт гаргах, бүртгэлээс хасах

ЗУРГАА. ҮНЭТ ЦААС ТУСГААРЛАХ, ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖ ДАХЬ ДАНСНЫ ГҮЙЛГЭЭГ ТҮР ЗОГСООХ

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл /цаашид “Хорооны бүртгэл” гэх/-д бүртгүүлэх хүсэлт гаргах, хүсэлтийг хянах, бүртгэхээс татгалзах, бүртгэсэн үнэт цаасыг нийтэд танилцуулах, анхдагч зах зээлд гаргах, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

~~1.2. Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг арилжаа эрхлэх байгууллагын “Бүртгэлийн журам” аар зохицуулна.~~

1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх харилцааг тус тусын үйл ажиллагааг нь тусгайлан зохицуулсан Хорооны журмаар зохицуулна.

ХОЁР. НИЙТЭД САНАЛ БОЛГОН АНХ УДАА ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ

2.1. Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргах

2.1.1. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

2.1.1.1. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл /Нэгдүгээр хавсралтад заасан Маягт-СЗХ03101-ийн дагуу/;

2.1.1.2. үнэт цаасны танилцуулга;

2.1.1.3. үнэт цаас гаргах, түүнд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр, холбогдох нотлох баримт бичиг;

2.1.1.6. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6, 10.8 дахь хэсэгүүдэд заасан хуулийн этгээдийн дүгнэлт, хөндлөнгийн шинжээч, мэргэжилтний үнэлэлт, дүгнэлт, арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт;

2.1.1.7. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай төлбөрийн баримт.

2.1.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.3-т заасан хуулийн этгээд нь гадаад улсын зохицуулах байгууллага, арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн тохиолдолд тухайн эрх бүхий байгууллагын шийдвэрийн хувь болон Хоёрдугаар хавсралтад заасан Маягт-СЗХ03102-ын дагуу бэлтгэсэн үнэт цаасны танилцуулгыг ажлын таван өдөрт багтаан Хороонд хүргүүлнэ.

2.2. Үнэт цаас гаргагчийн хүсэлтийг хянах:

2.2.1. Хороо нь энэхүү журмын 2.2.2, 3.2.3-д тус тус заасан дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянана.

2.2.2. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дахь заалтад заасан шалгуурыг хангасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, дүгнэлт гаргуулах бөгөөд дүгнэлтэд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

2.2.2.1. үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх;

2.2.2.2. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан шаардлага хангасан эсэх болон тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал;

2.2.2.3. үнэт цаас гаргагчийн дүрэм, дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т нийцсэн эсэх;

2.2.2.4. бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;

2.2.2.5. сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;

2.2.2.6. үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа

үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;

2.2.2.7. үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх;

2.2.2.8. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;

2.2.2.9. компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлох.

2.3. Хорооны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах, үнэт цаасны танилцуулгыг олон нийтэд танилцуулах:

2.3.1. Хороо нь энэхүү журмын 3.2.3-т заасан арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт, 2.2.2-т заасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн дүгнэлтийг тус тус хянаж, холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэхээс татгалзах үндэслэлгүй бол үнэт цаас гаргагчийн үнэт цаас, түүний танилцуулгыг Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.3.2. Засгийн газар бүхэлд нь баталгаа гаргасан үнэт цаасыг бүртгэх, гаргасан хувьцааг нэгтгэх эсхүл хуваах замаар бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахад арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлтийг үндэслэн Хорооны бүртгэлд бүртгэнэ. Бүрдүүлбэр гэдэгт, үнэт цаасны төрөл, нэрлэсэн үнэ, үнэт цаас гаргагчийн оноосон нэр, зарласан үнэт цаасны тоо ширхэг, эргэлтэд гаргасан үнэт цаасны тоо ширхэг, арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх, өрийн хэрэгслийн хүү, хугацаа, төрөл, өрийн хэрэгслийн хүү төлөгдөх нөхцөл, үнэт цаасны төлбөр хийгдэх нөхцөлийг тус тус хамааруулна. /

2.3.3. Гаргасан хувьцааг нэгтгэх эсхүл хуваахад зарласан эсхүл халаасны хувьцааны бүрдүүлбэрт нэгтгэсэн эсхүл хуваасан хэмжээгээр дүйцүүлэн үнэт цаасны бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулна.

2.3.4. Хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд, үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг бүртгэхээс татгалзана.

2.3.5. Хороо нь үнэт цаас, түүний танилцуулгыг бүртгэх, бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах тухай шийдвэрийг үнэт цаас гаргагч, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, арилжааны төлбөр, тооцооны байгууллага болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

2.3.6. Хороо нь үнэт цаасыг ямар нэгэн нөхцөл болзолтойгоор бүртгэхгүй.

2.3.7. Хороо нь үнэт цаасыг бүртгэх үед компанийн хяналтын багцыг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн үнэт цаасыг тодорхой хугацаанд Хорооны шийдвэрээр тусгаарлаж болох бөгөөд тусгаарлалтын хугацааг нэг удаа сунгаж болно.

2.3.8. Энэхүү журмын 2.3.7-д заасан тусгаарлагдсан хувьцааг тусгаарлалтаас чөлөөлөх нөхцөл бүрдсэн гэж үзвэл чөлөөлөх тухай Хорооны тогтоол гаргана.

2.3.9. мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээд, андеррайтерийн компанитай үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, худалдах асуудлаар урьдчилан хэлэлцээр хийснийг нийтэд санал болгосонд тооцохгүй.

2.3.10. Үнэт цаас гаргагч болон түүний андеррайтер нь Хороонд бүртгүүлсэн үнэт цаасны танилцуулгыг нийтэд үнэ төлбөргүй хүргэх бөгөөд сонирхсон бүх этгээдийг танилцах боломжоор хангасан байна.

2.3.11. Олон нийтэд түгээх мэдээлэл нь Хорооны бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасны танилцуулгын агуулгад нийцсэн байна.

2.3.12. Үнэт цаас, түүний танилцуулгыг бүртгэх, бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах тухай Хорооны шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор арилжаа эрхлэх байгууллага Хорооны шийдвэрийг хэрэгжүүлнэ.

2.4. Анхдагч зах зээлд арилжаалах, тайлагнах, бүртгэлийг хүчингүй болгох:

2.4.1. Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь үнэт цаасыг Хороонд бүртгүүлснээс хойш зургаан сарын дотор анхдагч зах зээлд гарган нийтэд санал болгон арилжаална.

2.4.2. Үнэт цаасыг нийтэд танилцуулах ажиллагаа дуусгавар болсон үед Хороонд бүртгэгдсэн танилцуулгад заасан арга хэлбэрээр үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулна.

2.4.3. Андеррайтер, эсхүл үнэт цаас гаргагч нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг, эсхүл захиалгын бүртгэлийг эхлүүлэх зөвшөөрлийг Хорооноос авах ба энэ тухай хүсэлтийг уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө Хороонд гаргах бөгөөд хүсэлтэд хугацаа, хуваарийг тодорхой тусгасан байна.

2.4.4. Анхдагч зах зээлд байршуулахаар захиалгын бүртгэл хийх, эсхүл арилжаалагдах хугацаа нь захиалгын бүртгэл эхэлсэн, эсхүл үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалж эхэлсэн өдрөөс хойш нэг сараас илүүгүй байна.

2.4.5. Нийтэд санал болгон нэмж гаргах үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд энэхүү журмын 2.4.1, 2.4.4-т заасан хугацаа нэгэн адил хамаарна.

2.4.6. Анхдагч зах зээлийн арилжааг өрийн хэрэгслийн хувьд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсэгт заасан нөхцөлд, хувьцааны хувьд хуульд заасан болон дараах нөхцөлд амжилттай явагдсанд тооцно.

2.4.6.2. үнэт цаасны танилцуулгад заасан хувь, хэмжээгээр арилжаалж, шаардагдах хэмжээний санхүүжилтийг татан төвлөрүүлсэн.

2.4.7. Хороо энэхүү журмын 2.4.6.2-т заасан болон түүнээс дээш хэмжээнд арилжаалагдсан хувьцааг компанийн гаргасан хувьцааны, үлдэх хувьцааг зарласан хувьцааны бүртгэлд тус тус бүртгэнэ.

2.4.9. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 3.1.4-т заасны дагуу варрант гаргасан бол уг санхүүгийн хэрэгслийг эзэмшигч нь анхдагч зах зээлийн арилжаа, эсхүл захиалгын бүртгэл явагдаж дуусахаас өмнө үнэт цаасны зохих төлбөрийг гүйцэтгэсэн байна.

2.4.10. Варрант эзэмшигч нь үнэт цаас худалдан авах эрхээ тодорхой нөхцөлөөр бусдад шилжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд эрх хүлээн авагч нь энэхүү журмын 2.4.9-д заасан хугацаанд үнэт цаасны зохих төлбөрийг гүйцэтгэнэ.

2.4.11. Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа, эсхүл захиалгын бүртгэл явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан арилжааны тайланг энэхүү журмын Гуравдугаар хавсралтад заасан Маягт-СЗХ03103-ын дагуу Хороонд хүргүүлнэ.

2.4.12. Энэхүү журмын 2.4.6-д заасан нөхцөл бүрдээгүй тохиолдолд Хороо нь тухайн үнэт цаасны бүртгэлийг хүчингүй болгож, анхдагч зах зээлийн хэлцлийг буцаана.

2.4.13. Хороо нь энэхүү журмын 2.4.11-т заасан тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл болон арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

2.4.14. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 2.4.11-т заасан хугацаанд багтаж үнэт цаасны гүйлгээний товч тайланг нийтэд мэдээлнэ. Хэрэв нээлттэй компани болон өөрчлөгдөж анх удаагаа хувьцаагаа нийтэд санал болгон худалдсан бол уг мэдээлэлд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг тусгасан байна.

ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ, АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА, ХОРООНЫ ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Үнэт цаас гаргагч нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ:

3.1.1. Үнэт цаас гаргагч нь анх удаа нийтэд санал болгох үнэт цаас гаргах бол энэ тухай хүсэлтээ Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад нэгэн зэрэг гаргаж болно.

3.1.3. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг бүртгэхээс татгалзсан тухай Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Хорооны Хяналтын зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

3.1.4. Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг тодорхой үнэ, хувь хэмжээгээр худалдан авах эрхийг гэрчлэх варрант гаргах эрхтэй.

3.1.5. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгүүлэх, бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах эсхүл бүртгэлээс хасуулахтай холбоотой Хороонд гаргасан хүсэлтээ хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх явцын мэдээ, мэдээллээр хангагдах эрхтэй.

3.1.6. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, компанийн хэлбэрийг өөрчлөх, өрийн хэрэгсэл гаргагч нь үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж, барагдуулан үнэт цаасаа бүртгэлээс хасуулах тохиолдолд энэ тухай хүсэлтээ Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад нэгэн зэрэг гаргана.

3.1.7. Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой Хорооноос шаардсан тодруулга, нэмэлт баримт бичгийг заасан хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.

3.1.8. Төсөл хэрэгжүүлэх зорилго бүхий үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд хагас жил бүр төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын зардлын зүйл, ангилал тус бүрээр нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомжид нийцүүлэн гаргасан дэлгэрэнгүй тайланг санхүүгийн тайлангийн хамт дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд хүргүүлэхээс гадна өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд тогтмол мэдээлэх үүрэгтэй.

3.1.9. Үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын кодексийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах бөгөөд хувьцаа эзэмшигчийн эрх, ашгийг хамгаалах чиглэлээр компанийн ногдол ашгийн бодлогыг боловсруулан баталж, мөрдөх үүрэгтэй.

3.1.10. Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийн барьцаа хөрөнгийн бүртгэлийг барьцааны эд хөрөнгийг бүртгэх төрийн эрх бүхий байгууллага, төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

3.1.11. Үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд хүргүүлсэн үнэт цаасны танилцуулга, түүнд хавсаргасан холбогдох бүх баримт бичиг, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой материалыг Хорооны бүртгэлд бүртгэх тухай тогтоол гарснаас хойш арван жилийн хугацаанд өөр дээрээ хадгалах үүрэгтэй.

3.1.12. Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол болон тухай бүр хүргэх үүрэгтэй.

3.1.12.1. Үнэт цаас гаргагчийн нийтэд, тогтмол хүргэх мэдээлэл нь Дөрөвдүгээр хавсралтад заасан хэлбэртэй, хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлан байна.

3.1.12.2. Үнэт цаас гаргагч нь хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор, жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор тус тус энэ журамд заасны нийтэд мэдээлнэ.

3.1.12.5. Үнэт цаас гаргагч нь Тавдугаар хавсралт дахь тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэлд заасан аливаа үйл явдал, өөрчлөлтийн талаар тухайн үйл явдал, өөрчлөлт болсноос хойш ажлын 1 өдөрт багтаан нийтэд мэдээлэх үүрэгтэй.

3.1.13. Энэ журмын 4 дүгээр болон 5 дугаар хавсралтуудад заасан мэдээллийг өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсанд байршуулах үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэх бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасны дагуу мэдээллийн үнэн зөвийг компани хариуцна.

3.1.14. Үнэт цаас гаргагч энэ журмын 3.1.13-д заасан этгээдийн нэр, албан тушаалыг томилсноос хойш ажлын 3 өдрийн дотор арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

3.1.15. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь мэдээллийг нийтэд хүргэхдээ үнэт цаас гаргагчийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсанд өөрөө байршуулна.

3.1.16. Үнэт цаас гаргагч энэ журамд заасан мэдээллийг нийтэд хүргэх харилцааг зохицуулсан дотоод журам баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж болно.

3.1.17. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь үнэт цаас гаргагчаас мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж, гарсан үр дагаврыг хариуцна.

3.1.18. Шаардлагатай гэж үзвэл арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаас гаргагчаас нийтэд хүргэж буй мэдээлэлд орсон тоон үзүүлэлт, санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг нэмж шаардаж нийтэд танилцуулах болно.

3.1.19. Арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар нийтэд мэдээлсэн мэдээллээс бусад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар тархсан цуурхал, худал, ташаа мэдээлэл нь компанийн үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхөөр бол арилжаа эрхлэх байгууллага үнэт цаас гаргагчаас нэмж мэдээлэл, тайлбар гаргуулж нийтэд хүргэж болно.

3.1.20. Арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсанд олон нийтэд мэдээлсэн мэдээллийг компанийн албан ёсны мэдээлэл гэж үзэх бөгөөд бусад олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэж болно.

3.1.21. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь энэ журмын 3.2.10-т заасан эрхийг үнэт цаас гаргагчийн ТУЗ зөвшөөрсөн тохиолдолд бусдад дамжуулах, ашиглуулах боломжтой.

3.1.22. Үнэт цаас гаргагч нь бэлэн мөнгө эсхүл компанийн хувьцаа болон бусад этгээдийн үнэт цаас хэлбэрээр хуваарилсан ногдол ашгийг зөвхөн эрх бүхий зуучлагч байгууллага болох төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан гэрээ-ний үндсэн дээр тараах үүрэгтэй.

3.1.23. Үнэт цаас гаргагч нь ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг Хорооноос тогтоосон хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын хүрээнд хувьцаа эзэмшигчдэд хүргэх үүрэгтэй.

3.1.24. 3.1.23-т заасан мэдээллийн хувийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалын хамт Хороонд ирүүлнэ.

3.1.25. Гэрээ байгуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор хувьцаа эзэмшигчид болон үнэт цаасны компаниудад мэдээллийг хүргэнэ.

2бөдөрт3.1.27. Хэрэв хувьцаа эзэмшигч нь төвлөрсөн хадгаламжийн байгууллагад дансгүй бол түүнд хуваарилагдсан ногдол ашгаас нь данс нээлгэх хураамжийг суутган авч, үлдэгдлийг тухайн дансанд нь байршуулна.

3.1.28. Давуу эрхийн хувьцаа болон тухайн компанийн тав буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчид нь арилжааны банк дахь өөрийн харилцах болон хадгаламжийн дансанд ногдол ашгийг шилжүүлж авахаар бичгээр хүсэлт гаргаж, холбогдох мэдээллийг өгсөн тохиолдолд ногдол ашгийг хувьцаат компани хувьцаа эзэмшигчийн дансанд байршуулж болно.

3.1.29. Ногдол ашиг хуваарилалтын тайланг энэ журмын Зургаадугаар хавсралтад заасан Маягт-СЗХ03104-ийн дагуу гаргаж, жилийн санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлэх үүрэгтэй.

3.2. Арилжаа эрхлэх байгууллага дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ:

3.2.1. Арилжаа эрхлэх байгууллага нь өөрийн бүртгэлийн шаардлага, шалгуурыг хангаагүй, түүний өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг өөрийн бүртгэлээс хасах эрхтэй.

3.2.2. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасны бүртгэлийн ангиллын шалгуур үзүүлэлтийг үнэт цаас гаргагч хангаж байгаа эсэх, бизнес төлөвлөгөө болон түүний эдийн засгийн үндэслэл нь бодитой эсэх, нийтэд санал болгож байгаа үнэт цаасны танилцуулгын бүрдэл зэргийг хянах үүрэгтэй.

3.2.3. Арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 3.2.2-д заасан ажиллагааг ажлын 14 өдрийн дотор гүйцэтгэн энэхүү журмын Долоодугаар хавсралтад (Маягт-СЗХ03105-ын дагуу) заасан дүгнэлтийг ажлын хоёр өдрийн дотор Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

3.2.4. Арилжаа эрхлэх байгууллага нь өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтийн баталгаа, барьцаа хөрөнгийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй бөгөөд тухайн өрийн хэрэгслийн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавих үүрэгтэй.

3.2.5. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахаар ирүүлсэн хүсэлтийг өөрийн журмын дагуу хянаж энэхүү журмын Долоодугаар хавсралтад заасан дүгнэлтийг, үнэт цаас гаргагчийн ирүүлсэн баримт бичгийн хуулбарын хамт ажлын хоёр өдрийн дотор Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

3.2.8. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасыг өөрийн бүртгэлээс хассан тухай шийдвэрийг энэхүү журмын Наймдугаар хавсралтад (Маягт-СЗХ03106-ын дагуу) заасан дүгнэлтийг ажлын хоёр өдөрт багтаан үнэт цаас гаргагч болон Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

3.2.10. Арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 4 дүгээр болон 5 дугаар хавсралтуудад заасан мэдээллийг өөрийн цахим хуудсанд оруулах эрх /нууц дугаар бүхий эрх/-ийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх үүрэгтэй.

3.2.11. Арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 4 дүгээр болон 5 дугаар хавсралтуудад заасан үнэт цаас гаргагчийн нийтэд мэдээлэх мэдээллийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй бөгөөд холбогдох тайланг Хороонд улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх үүрэгтэй.

3.2.12. Арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 3.2.10-т заасан мэдээллийг зохих журмын дагуу нийтэд хүргэх үүргийг биелүүлээгүй компанид зөрчил гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан шаардлага хүргүүлж ажиллах бөгөөд зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд энэ талаарх мэдээллийг Хороонд ирүүлэх үүрэгтэй.

3.2.13. Энэхүү журмын 3.3.6 дахь заалтын дагуу гаргасан Хорооны шийдвэрийг арилжаа эрхлэх байгууллага олон нийтэд мэдээнэ.

3.2.13. Энэ журмын 3.2.10-т заасан нийтэд хүргэх мэдээллийн нэгдсэн маягт, загварын зааврыг Арилжаа эрхлэх байгууллага тогтооно.

3.3. Хороо нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ:

3.3.1. Хорооны хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрийг Хорооны тогтоолоор батална:

3.3.1.1. Компанийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх эсэх;

3.3.1.2. Урьд нь нийтэд санал болгон гаргасан тухайн төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд нэмж гаргах үнэт цаасыг бүртгэх эсэх;

3.3.1.3. Урьд нь нийтэд санал болгон гаргасан хуулийн этгээд өөр төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд гаргах үнэт цаасыг бүртгэх эсэх;

3.3.1.4. Үнэт цаас гаргагчийн компанийн хэлбэрийг өөрчлөх, компанийг өөрчлөн байгуулахтай холбоотойгоор тухайн үнэт цаасны бүртгэлд орох өөрчлөлтийг бүртгэх эсэх;

3.3.1.5. Үнэт цаасыг бүртгэлээс хасах.

3.3.2. Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, зарласан үнэт цаасны тоо ширхэгт орох өөрчлөлтийг Хорооны даргын тушаалаар бүртгэнэ.

3.3.3. Энэхүү журмын 3.3.2-т зааснаас бусад бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэрийг Хорооны тогтоолоор батална.

3.3.5. Хороо нь энэхүү журмын 3.2.1-д заасан үндэслэлээр арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдсан үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг хаалттай хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэлд бүртгэнэ.

3.3.6. Хороо энэ журмын 3.2.11-д заасны дагуу арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу зөрчлийг арилгуулах талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх бөгөөд биелэлтийг хангаагүй тохиолдолд холбогдох хариуцлага ногдуулж, олон нийтэд мэдээнэ.

3.3.7. Арилжаа эрхлэх байгууллагын энэ журмын 3.2.12-т заасан мэдээллийг үнэт цаас гаргагч нийтэд тогтмол хүргэх үүргийн хэрэгжилтийг хангуулж байгаа эсэхэд Хороо хяналт тавьж ажиллана.

ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

4.1. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах:

4.1.1. Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэрийг хууль болон тухайн компанийн дүрэмд заасан эрх бүхий байгууллага гаргана.

4.1.2. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах хүсэлтийг энэхүү журмын 3.1.6-д заасны дагуу Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад нэгэн зэрэг гаргаж болох бөгөөд Хороо тус компанийн нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд орох өөрчлөлтийг бүртгэнэ.

4.2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах, хүсэлтийг хянах, Хорооны бүртгэлд өөрчлөлт оруулах:

4.2.1. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

4.2.1.1. үнэт цаасны бүрдүүлбэрт орох өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 1-д заасан Маягт-СЗХ03101-ын дагуу/;

4.2.1.2. үнэт цаас гаргах, түүнд өөрчлөлт оруулах тухай эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэр, холбогдох нотлох баримт бичиг;

4.2.1.3. энэхүү журмын 4.2.2-т заасан хууль зүйн дүгнэлт болон аудитын дүгнэлт, бизнесийн үнэлгээний тайлан, хөрөнгийн үнэлгээний тайлан;

4.2.1.4. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийн мэдээ, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад ногдол хувь байршуулсан талаарх мэдээлэл;

4.2.1.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

4.2.2. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны энэхүү журмын 3.3.2-т зааснаас бусад бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дахь заалтад заасан шалгуурыг хангасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, дүгнэлт гаргуулах бөгөөд дүгнэлтэд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

4.2.2.1. үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэр нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэх;

4.2.2.2. бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;

4.2.2.3. сүүлийн 3 жил дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;

4.2.2.4. үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажиллагаа нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн эсэх.

4.2.3. Үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор үнэт цаас гаргагчийн Хороонд хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн гурван жилийн дотор хийлгэсэн хараат бус үнэлгээ, аудитын байгууллагын дүгнэлтийг ашиглаж болно.

4.2.4. Хороо нь энэхүү журмын 3.2.5-д заасан арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт, 4.2.2-т заасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн дүгнэлтийг тус тус хянаж, холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэхээс татгалзах үндэслэлгүй бол үнэт цаас гаргагчийн үнэт цаасны бүрдүүлбэрт орох өөрчлөлтийг бүртгэх эсэх асуудлыг энэхүү журмын 3.3.3-д заасны дагуу Хороо шийдвэрлэн тогтоол гаргана.

4.2.5. Үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах тухай Хорооны шийдвэр гарсны дараа ажлын тав өдөрт багтаан Хорооны Ажлын алба үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

ТАВ. ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

5.1. Үнэт цаасыг Хорооны бүртгэлээс хасуулах хүсэлт гаргах, бүртгэлээс хасах:

5.1.1. Үнэт цаас гаргагч нь компанийн хэлбэрийг өөрчлөх, татан буугдах, өрийн хэрэгсэл гаргагч нь үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж, барагдуулсан болон хуульд заасан бусад тохиолдолд тухайн үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Хорооны бүртгэлээс хасна.

5.1.2. Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсхүл тухайн байгууллагын бүртгэлээс хасагдсан үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгэлээс хасуулахдаа дараах баримт бичгийг Хороонд хүргүүлнэ. Үүнд:

5.1.2.1. албан хүсэлт;

5.1.2.2. Энэхүү журмын 3.2.8-д заасан дүгнэлт;

5.1.2.4. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад байршуулсан ногдол хувийн талаарх мэдээлэл болон компанийн хувьцаа эзэмшигчийн тусгаарлагдсан хувьцааны талаарх мэдээ, мэдээлэл;

5.1.2.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн төлбөрийн баримт.

5.1.4. Компанийн хэлбэр өөрчлөгдсөн үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь үнэт цаас гаргагч болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад тус тус хүргүүлнэ.

5.1.5. Хороо нь үнэт цаасыг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг үнэт цаас гаргагч, арилжаа эрхлэх болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

5.1.6. Үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай Хорооны шийдвэр гарахад Хорооны Ажлын алба энэ тухай ажлын 10 өдөрт багтаан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

ЗУРГАА. ҮНЭТ ЦААС ТУСГААРЛАХ, ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖ ДАХЬ ДАНСНЫ ГҮЙЛГЭЭГ ТҮР ЗОГСООХ

6.1. Үнэт цаасыг тусгаарлах, тусгаарлалтыг цуцлах, төвлөрсөн хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсоох, гүйлгээг сэргээх шийдвэрийг Хорооны улсын байцаагч /цаашид улсын байцаагч гэх/ шийдвэр гаргана.

6.2. Энэхүү журмын 6.1-т заасан шийдвэрийн хувийг холбогдох өмчлөгчийн үндсэн брокер, дилерийн компанид хүргүүлэх ба харьяалах брокер, дилерийн компани өөрийн үндсэн харилцагчид шуурхай мэдэгдэх үүрэгтэй.

6.3. Үнэт цаасыг тусгаарлах нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомжид өөрөөр заагаагүй бол тухайн үнэт цаасыг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалахаас бусад эрхийг хязгаарлахгүй.

6.4. Үнэт цаасыг зөвхөн дараах үндэслэлээр улсын байцаагч тусгаарлах ба шаардлагатай гэж үзвэл хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсооно:

6.4.1. Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг худалдан авсан этгээд уг үнэт цаасыг худалдан авснаас хойш ажлын 10 өдрийн дотор Хороонд мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

6.4.2. Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа хувьцааг худалдан авахаар санал болгох үүргээ биелүүлээгүй;

6.4.3. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах үүднээс тухайн үнэт цаасны арилжааг зөрчилтэй байх үндэслэлтэй буюу арилжаанд оролцогч талын үнэт цаастай холбоотой гаргасан гомдол, хүсэлтийг үндэстэй гэж үзсэн, хянан шалгах ажиллагаа явагдах хугацаанд уг үнэт цаасыг бусдад арилжих замаар шийдвэр биелүүлэх ажиллагаанд хүндрэл гарч болзошгүй гэж үзсэн;

6.4.4. Шүүхийн шийдвэрээр;

6.4.5. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзсэн буюу зөрчсөн нь тогтоогдсон бусад үндэслэл.

6.5. Үндсэн дансны гүйлгээг түр зогсооход тухайн данс дахь холболтын бүх дансаар хийх гүйлгээг давхар зогсооно.

6.6. Тухайлан аль нэг холболтын дансны гүйлгээг нь түр зогсоохоор шийдвэрлэсэн бол энэ нь үндсэн данс болон бусад холболтын дансанд хамаарахгүй.

6.7. Үнэт цаас тусгаарлах болон хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсоох болсон шалтгаан, нөхцөл арилсан тохиолдолд тухайн шийдвэрийг гаргасан улсын байцаагч буюу улсын ахлах байцаагч, эсхүл ерөнхий байцаагчийн шийдвэрээр үнэт цаасны тусгаарлалтыг цуцлах буюу хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг сэргээнэ.

6.8. Хугацаа зааж үнэт цаас тусгаарласан буюу дансны гүйлгээг түр зогсоосон бөгөөд уг хугацаа дуусгавар болсон, хугацааг үргэлжлүүлэн сунгах тухай улсын байцаагчийн шийдвэр дахин ирээгүй тохиолдолд үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага бие даан тусгаарлалт цуцлах буюу дансны гүйлгээ сэргээж энэ талаар Хороонд мэдэгдэнэ.

6.9. Хорооны улсын байцаагчийн албан шаардлагын дагуу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хаалттай хувьцаат компанийн хувьцааг тусгаарлаж болно.

6.10. Хаалттай хувьцаат компанийн хувьцааг тусгаарлалтаас чөлөөлөхдөө тусгаарлуулсан этгээд эсхүл дээд шатны албан тушаалтны шийдвэр, хувьцаа эзэмшигчийн хүсэлтийг үндэслэнэ.

ДОЛОО. Үнэт цаасны арилжааг зогсоох

7.1. Хороо нь зах зээлийн хэвийн үйл ажиллагаа түр хугацаагаар эрсдэлд орсон буюу орж болзошгүй, эсхүл хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл дараах үндэслэлээр үнэт цаасны арилжааг зогсооно:

7.1.1. Бүртгэлийн шаардлага хангахгүй болсон;

7.1.2. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасан хоёрдогч зах зээлийн мэдээллээ нийтэд толилуулах үүргээ биелүүлээгүй;

7.1.3. Үнэт цаас гаргагч нь хууль, журмын дагуу санхүүгийн мэдээллээ нийтэд мэдээлээгүй;

7.1.4. Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох шаардлага үүссэн;

7.1.5. Үнэт цаас гаргагч нь санхүүгийн байдлаа үнэн зөв үнэлж, зах зээлд оролцогчдыг холбогдох мэдээллээр хангах чадваргүй болсон;

7.1.6. Үнэт цаас гаргагчийн өөр хөрөнгийн бирж дээрх тухайн үнэт цаасны арилжааг эрх бүхий байгууллага нь зогсоох эсхүл түдгэлзүүлсэн;

7.1.7. Хороо шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд.

7.2. Үнэт цаасны арилжааг зогсоосон нь үнэт цаас гаргагчийг хууль болон энэ журамд заасан мэдээллийг ил тод болгох болон бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

7.3. Хороо үнэт цаасны арилжааг зогсоох тухай шийдвэрт уг шийдвэрийг цуцлах нөхцөлийг тодорхой тусгана.

7.4. Хороо үнэ ханшийг тодорхой түвшинд байлгах зорилгоор үнэт цаасны арилжааг зогсоож болохгүй.

7.5. Бүртгэлтэй компанийн хувьцаа нь нийтийн эзэмшилд байвал зохих хувиас бага байгааг тогтоовол Хороо уг компанийн үнэт цаасны арилжааг зогсоох хугацааг тогтоох бөгөөд тогтоосон хугацаанд энэхүү хувь хэмжээний нөхцөлийг хангаагүй бол заасан хугацаанд үнэт цаасны арилжааг зогсооно.

7.6. Энэ журмын 21.5-д заасан нөхцөл байдал үүсч үнэт цаасны арилжааг нь зогсоосон өдрөөс хойш ажлын 28 өдрийн дотор нийтийн эзэмшилд буй бүх хувьцааг сүүлийн зургаан сарын зах зээлийн жигнэсэн дундаж ханшаас багагүй үнээр худалдаж авна.

7.7. Нийтийн эзэмшилд буй хувьцааны зах зээлийн үнэ тогтоогүй бол компани нийтийн эзэмшилд буй бүх хувьцааг анхны худалдагдсан үнээр худалдаж авна.

7.8. Бүртгэлтэй компани нь энэ журмын 21.6-д заасан хугацаанд нийт хувьцааны нийтийн эзэмшилд байвал зохих хувь хэмжээний нөхцөлийг хангаж Хорооны бүртгэлд хэвээр үлдэх хүсэлт гаргавал Хороо тухайн компанийн үнэт цаасны арилжааг сэргээнэ.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Энэхүү журмын 8.1-д заасан хариуцлага хүлээлгэсэн нь тухайн этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааны журам”-ын 1 дүгээр хавсралт

Маягт СЗХ03101

